



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Янжмаа/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/ -д тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

141223244

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 09 - ны өдрийн 1/45 дугаар тушаалын хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	18/2023	3 жил	2023.02.07	2026.02.07
2.	Дархан-Уул аймаг, Гэрэлтэй өрхийн эрүүл мэндийн төв	19/2023	2 жил	2023.03.01	2025.03.01
3.	Дархан-Уул аймаг, "Саран элит" ХХК-ийн клиник эмнэлэг	20/2023	2 жил	2023.03.01	2025.03.01
4.	Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сумын эрүүл мэндийн төв	21/2023	2 жил	2023.02.14	2025.02.14

оо0оо